



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠘ оны ᠕ сарын ᠔ өдөр

Дугаар ᠔᠒᠒

Улаанбаатар хот

“Хүүхдийн сэргээн засах “Хан туул төв”-ийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,763,816.00 (найман сая долоон зуун жаран гурван мянга найман зуун арван зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хүүхдийн сэргээн засах “Хан туул төв” (Ө.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 3 нэр төрлийн 779,000.00 (долоон зуун далан есөн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 7 нэр төрлийн 7,984,816.00 (долоон сая есөн зуун наян дөрвөн мянга найман зуун арван зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Хүүхдийн сэргээн засах “Хан туул төв” (Ө.Батжаргал)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501989



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А.11. дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хүүхдийн сэргээн засах Хан туул төв

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил			Хэмжээ нэгж	Тог хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Эвдрэл гэмтэл үнэ	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	ҮХХХК-ын хурлын шийдвэр
		Ашигласан жил	Хэмжээ нэгж	Тог хэмжээ									
1	Зөөврийн компьютер	5	ш	1	2,450,000.00		2,450,000.00		2,450,000.00	0.00	Атлах	1,000.00	Татах
2	Агаар цэвэршүүлэгч	5	ш	2	571,428.00		1,142,856.00		1,142,856.00	0.00	Атлах	1,000.00	Татах
3	Суурин компьютер	5	ш	1	1,750,000.00		1,750,000.00		1,750,000.00	0.00	Атлах	1,000.00	Татах
4	Шарах шүүгээ /дахин үнэлсэн/	2	ш	1	123,960.00		123,960.00		123,960.00	0.00	Атлах	0.00	Татах
5	Өнгөт принтер	5	ш	1	380,000.00		380,000.00		380,000.00	0.00	Атлах	1000.00	Татах
Машин тоног төхөөрөмжийн дүн													
1	Хүүхдийн ор /хуванцар/	5	ш	30	66,600.00		1,998,000.00		1,998,000.00	0.00	Атлах	15,000.00	Татах
2	Номын тавиур	5	ш	1	239,000.00		239,000.00		239,000.00	0.00	Атлах	1,000.00	Устгах
3	Бичгийн ширээ	5	ш	1	280,000.00		280,000.00		280,000.00	0.00	Атлах	1,000.00	Устгах
4	Буузны жигнүүр /дахин үнэлсэн/	2	ш	1	140,000.00		140,000.00		140,000.00	0.00	Атлах	1,000.00	Татах
5	Ширээ /дахин үнэлсэн/	2	ш	1	260,000.00		260,000.00		260,000.00	0.00	Атлах	1,000.00	Устгах
Тавилга, эд хогшлын дүн													
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн								2,917,000.00	2,917,000.00	0.00		19,000.00	
Үүнээс: Хоёрдогч түүхий эдээр худалдах хөрөнгө								8,763,816.00	8,763,816.00	0.00			
Атлах хөрөнгө								0.00					
Татан төвлөрүүлэх хөрөнгө								779,000.00					
Худалдсанаас олох орлого								7,984,816.00					
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/								0.00					